



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

“Хүрээ нүүдэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх
тухай

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.1 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2012 оны зорилтын 1.1.4 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөрийн дагуу нийслэлийн “Хүрээ нүүдэл” хөтөлбөрийн аяллын маршрутыг тогтоох, нийслэлийн түүхийг олон нийтэд сурталчилан таниулах аяллыг 2012 оны 07 сарын 15-наас 07 сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулахыг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /Д.Ганболд/, мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/ нарт үүрэг болгосугай.

2. “Хүрээ нүүдэл” нүүдэл хөтөлбөрийн удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Хүрээ нүүдэл” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн нүүдэллэж, суурьшиж байсан газруудад аяллын маршрут тогтоох ажлын зарцуулах төсөв нийт 2.068.000 /хоёр сая жаран найман мянга/ төгрөгийг батлагдсан төсвөөс тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

4. “Хүрээ нүүдэл” хөтөлбөрийг цаг хугацаанд нь зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /Д.Ганболд/, мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/ нарт даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

My Doc.\tushaal\.

115050000040

35 40
Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 2012 оны 17 сарын 17 өдрийн
35 тоот тушаалын 1-р хавсралт



**“ХҮРЭЭ НҮҮДЭЛ” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ТОГТООГДСОН
НИЙСЛЭЛИЙН НҮҮДЭЛЛЭЖ СУУРЬШИЖ БАЙСАН ГАЗРУУДЫН
ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙЖ, АЯЛАЛ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2012 оны 7 дугаар сар 16

Улаанбаатар хот.

Зорилго:

“Хүрээ нүүдэл” хөтөлбөрийн хүрээнд тогтоогдсон Нийслэлийн нүүдэллэж суурьшиж байсан газруудын хадгалалт, хамгаалалтанд үзлэг хийх, танин мэдэхүй, аялал зохион байгуулахад оршино.

Зохион байгуулагч:

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Соёл урлагийн газар

Оролцогч:

Чингэс хаан дээд сургууль

1. О.Сүхбаатар /Доктор, Хот судлаач/
2. Б.Лхагвасүрэн /Доктор, Хот судлаач/
3. Х.Шагдар /Доктор, Хот судлаач/
4. М.Отгончимэг /НСУГ-ын мэргэжилтэн/
5. Ө.Бум-Эрдэнэ /НСУГ-ын мэргэжилтэн/
6. О.Эрдэнэцэцэг /НСУГ-ын ня-бо/
7. Н.Ганболд /НАЖГ-ын мэргэжилтэн/
8. Ш.Ундармаа / НАЖГ-ын мэргэжилтэн /
9. Жолооч - 3

Хугацаа:

2012 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 2012 оны 07 дугаар сарын 25-ны өдөр

Маршрут:

1-р чиглэл:

1. Улаанбаатар
2. Хустай /Төв аймаг 3 сумын зааг/

- 41 36
3. Өнгөт /Төв аймаг/
 4. Ширээт цагаан нуур
 5. Улаан худаг
 6. Хөшөө цайдам
 7. Хар хорин /хоноглох/
 8. Түвшрүүлэх /Эрдэнэ толгой/
 9. Хархорин
 10. Улаан цутгалан
 11. Сангийн далай нуур /хужирт/
 12. 9-н зүйл
 13. Цогтын хадны бичээс /Төв аймаг Дэлгэрхаан/
 14. Улаанбаатар

5 хоног 6 өдөр

нийт 1600 км

2-р чиглэл:

1. Улаанбаатар
2. Хустай /Төв аймаг 3 сумын зааг/
3. Өнгөт /Төв аймаг/
4. Ширээт цагаан нуур
5. Хар хорин /хоноглох/
6. Түвшрүүлэх /Эрдэнэ толгой/ майханд/
7. Хар хорин
8. Хөшөө цайдам
9. Улаан худаг
10. Өгийн нуур /хоноглох/
11. Улаанбаатар

4 хоног 5 өдөр

нийт 1300 км

Нийт: 2900 км /10 хоног, 11 өдөр/

Хянасан :

Ахлах мэргэжилтэн

Г.Баясгалан

Боловсруулсан:

Мэргэжилтэн

Ш.Ундармаа

34
12
Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 2012 оны 12 сарын 17 өдрийн
35 тоот тушаалын 2-р хавсралт



“Хүрээ нүүдэл” хөтөлбөрийн хүрээнд
нийслэлийн нүүдэллэж суурьшиж байсан газруудын
хадгалалт, хамгаалалтыг шалгах ажлын төсөв

2012 оны 7 дугаар сар 16

Улаанбаатар хот.

№	Нэр	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1.	Унааны түрээс	75.000*11	2	1.650.000₮
2.	Томилолтын зардал	11 өдөр * 19000₮	2 хүн	418.000₮
3.	Нийт дүн			2.068.000₮

Хянасан: Нягтлан бодогч

П.Ариунаа

Төсөв гаргасан: Мэргэжилтэн

Ш.Ундармаа